ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 28 өдөр Дугаар А/14 Чойбалсан

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар
тахлаас урьдчилан сэргийлэх мэдээ,
мэдээллийн багийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/227 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны А/88 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, шуурхай арга хэмжээ авах ажиллагааны багийн Тандалт, халдварын сэргийлэлт, хяналтын бүлэгт нэмэлтээр ажиллах мэдээ, мэдээллийн багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Тандалтын багийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээг шуурхай арга хэмжээ авах ажиллагааны багийн ахлагчид тухай бүрт, бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг багийн ахлагч Г.Ариунзаяад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс /Я.Эрдэнэтуяа/-т даалгасугай.

ДАРГА Ч.ОЮУНАА

9031774 0719110006

Хөтлөх хэргийн 1.1-д

My Documents:TUSHAAI

310420102

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны
04 дугаар сарын 28-ны/ний өдрийн
А/14 дугаар/дүгээр тушаалын
хавсралт

МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН БАГ

| | | |
|---|---|---|
| Багийн ахлагч: | Г.Ариунзаяа | -Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд: | Б.Энхмаа | -Эрүүл мэндийн боловсрол, сургалт хариуцсан мэргэжилтэн |
| | М.Баяртунгалаг | -БЗДХ-ын тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн |

ooOoo